

Хэвлэлийн мэдээ

14-27

2015 оны 2 дугаар сарын 4-ний өдөр

“Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн гэрээнд гарын үсэг зурах ёслолын талаар


2 сарын 4-ний өдөр, Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Такэнори Шимизү нь Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс – Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр (*1)”-ийн хүрээнд хэрэгжүүлэх “Ховд аймгийн Жаргалант сумын “Цаст-Алтай” цогцолбор сургуулийн засварын төсөл”, “Хэнтий аймгийн Дархан сумын сургуулийн их засварын төсөл”, “Сэлэнгэ аймгийн Түшиг сумын сургуулийн засварын төсөл”, “Архангай аймгийн Цэцэрлэг сумын сургуулийн дотуур байрны их засварын төсөл”, “Дундговь аймгийн Сайнцагаан сумын “Эрдмийн Далай” цогцолбор сургуулийн дотуур байрны засварын төсөл”, “Дархан-Уул аймгийн Шарынгол сумын 2-р сургуулийн засварын төсөл” болон “Увс аймгийн Улаангом сумын 1-р сургуулийн дотуур байрны их засварын төсөл”-ийн гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү арга хэмжээнд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны дэд сайд Я.Төмөрбаатар хүрэлцэн ирсэн.

Монгол дахь “Өвсний үндэс – Хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийн хувьд боловсролын салбарыг онцгойлон анхаардаг бөгөөд энэ удаа гарын үсэг зурагдсан 7 төсөл нь бүгд боловсролын байгууллагын барилга байгууламжийн засвар буюу орон нутгийн боловсролын орчинг сайжруулахад хувь нэмэр оруулах төслүүд билээ.

Дээрхи 7 төсөлд нийт 623,199 ам.доллар буюу ойролцоогоор 1,209,006,060 төгрөгийн санхүүгийн тусламж үзүүлэхээр боллоо. Эдгээр 7 төсөл хэрэгжсэнээр 2014 оны санхүүгийн жилд “Өвсний үндэс – Хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол улсад хэрэгжүүлж буй төслийн тоо 19 болж байгаа бөгөөд нийт 1,711,992 ам.доллар буюу ойролцоогоор 3,204,995,625 төгрөг болох юм.

Япон улсын Засгийн Газар нь Монгол улсын боловсрол болон нийгмийн салбарт тулгамдаж буй олон асуудлыг бодит хэрэгцээнд нь тулгуурлан түргэн шуурхай шийдвэрлэхийн тулд цаашид ч “Өвсний үндэс – Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”-ийн бүхий л боломжийг ашиглан Монгол улсад тулгамдаж буй асуудлуудыг шийдэхэд хамтран ажиллахын зэрэгцээ тус улсын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг зорьж байна.

(*1) Япон улсын Засгийн газар 1989 оноос эхлэн “Өвсний үндэс - Хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ирсэн. Хөгжиж буй орнуудын орон нутгийн засаг захиргааны байгууллага, боловсрол болон эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлдэг энгийн ард иргэдэд шууд үр ашгаа өгөх, иргэдийн хэрэгцээнд тулгуурласан тусламжийг үзүүлэх төсөлд Япон улсын дипломат төлөөлөгчийн газрууд голлон санхүүгийн тусламж үзүүлдэг.



Элчин сайд Такэнори Шимизү, БСШУЯ-ны дэд сайд Я.Төмөрбаатар болон Засаг дарга нар



Элчин сайд Такэнори Шимизү болон Ховд аймгийн Засаг дарга Д.Цэвээнравдан нар
гэрээнд гарын үсэг зурах үеэр

ЛАВЛАХ УТАС:320777